

"СИЛИКАТ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.

- 1.1. Компанийн оноосон нэр
 - Бүрэн нэр (монголоор) "СИЛИКАТ" ХХК
 - Компанийн оноосон нэр англиар "....."Co.LTD гэж нэрлэнэ.
- 1.2. Компанийн оршин байгаа хаяг: - Хаяг:
 - Е мэйл: Утас:
- 1.3. "Силикат" ХХК нь (цаашид компани гэнэ) "Компанийн тухай" Монгол улсын хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэ дүрмээр хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллана.
- 1.4. Компани нь орлого ашгаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.
 - Хөнгөн бетон блок, шохойн үйлдвэрлэл
 - Монгол улсын хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа
- 1.5. Компани нь өөрийн салбар эсвэл төлөөлөгчийн газрыг бусад аймаг, хот, сум дүүрэг, хороонд ажиллуулна. Үүнийгээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- 1.6. Компани нь тодорхой мэргэжил тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаандаа холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлж, тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.
- 1.7. Компани нь улсын бүртгэлд орсон өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцогдоно.

ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ЭРХ.

- 2.1. Компани хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд "ХХК" гэсэн тэмдэглэгээг заавал хэрэглэнэ.
- 2.2. Компани нь "Силикат" ХХК-ийн Ерөнхий захиралын тушаал, хувьцаа эзэмшигчдийн хурлаас хүлээн зөвшөөрсөн дүрмээр байгуулагдана.
- 2.3. Компани өөрийн албан бичгийн хуудас, тамга тэмдэгтэй байна.
- 2.4. Компани өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар эсвэл бусадтай хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
- 2.5. Компани өөрийн үйл ажилагаагаа өргөтгөх, үйлчлүүлэгчид болон зах зээлд ойртох гэх мэт зорилгоор улс дотроо болон гадаадад салбар төлөөлөгчийн газар ажиллуулна.
- 2.6. Компанийн үндсэн ба туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

2.7. Компани нь төрийн болон бусад аж ахуйн нэгж байгууллага түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад элсэн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд төлөөлүүлэх, хамтран ажиллах зэргээр зохицуулалт хийнэ.

2.8. Компани өөрийн үйл ажиллагаатай холбоотой зарим зүйлийг хуулийн дагуу нууцлана.

2.9. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох мэдээлэл цуглуулах, мөн ийм мэдээллийг үйлчлүүлэгч сонирхогчдод хүргэнэ.

ГУРАВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ

3.1. Компани нь энэхүү дүрмийн 1.4-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхлэх үүрэгтэй.

3.2. Компани нь Монгол Улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хуулийн дагуу нягтлан бодохын болон анхан шатны, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулна.

3.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулиудын заалтыг хатуу мөрдөн татвараа өөрөө тодорхойлж сайн дураар төлнө.

3.4. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ мэдээллийг цаг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.

3.6. Компани нь улс эх орны нийгэм эдийн засгийн хөгжилд бололцооны хэрээр дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

3.7. Компани нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ХАРИУЦЛАГА.

4.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

4.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.3. Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

4.4. Компанийн гүйцэтгэх захирал ерөнхий нягтлан бодогч нар гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд тэдгээр нь өөрийн хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцна.

4.5. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд "Компаний тухай" хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

ТАВ. КОМПАНИЙН ДҮРМИЙН САН.

5.1. Компанийн дүрмийн сан нь 17,021,600 төгрөгийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө, 3,668,299,900 төгрөгийн үндэсний мөнгөн тэмдэгт (эсвэл валют) –ээс бүрдсэн нийт 868,223 төгрөгийн хөрөнгөтэй байна. Энэхүү хөрөнгө хувьцаанд хуваагдсан байх бөгөөд нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 46,334,602 ширхэг хувьцаа байна. Хувьцаа эзэмшигчид дараах байдлаар хувьцааг эзэмшинэ.

Үүнд:

Д/д	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзлэх хувь
1	Ц.Содбилэг	7 511 526	16,21
2	Ц.Сэргэлэн	451 704	0,98
3	Н.Цогцлон	2 258 520	4,87
4	Д.Энхболд	3 845 502	8,30
5	В.Мөнхтуяа	3 613 455	7,80
6	С.Золбоотөгс	6 539 619	14,12
7	С.Оджаргал	5 699 223	12,30
8	Халаасны хувьцаа	15 832 926	34,17
9	Бусад	192 753	0,42
Нийт		45 945 228	99,17

5.2. Хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилсэн үнэт цаас болно.

5.3. Компанийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байх бөгөөд энгийн хэлбэртэй байна.

5.4. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр дүрмийн сангаа нэмэгдүүлж болно.

5.5. Шаардлагатай нөхцөлд үүсгэн байгуулагчдын санаачлага, хамтын шийдвэрээр дүрмийн санд шинээр хөрөнгө оруулна.

5.6. Үйл ажиллагааны зарим чиглэлээр охин компани байгуулан дүрмийн сангаа тэр хэмжээгээр хорогдуулж болно.

5.7. Компанийн өөрийн хөрөнгө буюу дүрмийн санд оруулсан хөрөнгийн бүртгэл жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бүр оруулж байна.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ .

6.1. Компанийн гэрээ дүрэмд заасан журмын дагуу компанийн үйл ажиллагааг удирдахад оролцоно.

6.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх.

6.3. Эзэмшиж буй ногдол хувь хэмжээгээр ногдол ашиг авах.

6.4. Компанийн үйл ажиллагааны байдал, санхүүгийн болон бусад бичиг баримт, мэдээ тайлантай танилцах.

6.5. Компанийн эрх барих болон захиргааны байгууллагад санал оруулах, хэлэлцүүлэх.

6.6. Компанийг татан буулгах үед өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.

6.7. Хувьцаа болон хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах.

6.8. Хувьцаа эзэмшигч нас барсан тохиолдолд өв залгамжлагч нь компанийн гишүүнээр элсэх эрхтэй.

ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ.

7.1. Компанийн гэрээ, дүрмийн заалтыг хэлбэрэлтгүй сахих.

7.2. Компанийн үйл ажиллагаанд бололцоотой бүх талын дэмжлэг үзүүлэх.

7.3. Компанийн хувьцааг давуу эрхээр худалдан авах тухай саналаа хувьцааг худалдах шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлэх.

7.4. Компанийн нууцыг чандлан хадгалах.

7.5. Хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцаанд чин шударга хандах

7.6. Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол эрхэлсэн ажлаа үлгэр жишээ биелүүлэх.

7.7. Хувьцаа эзэмшигч өөрийн буруугаас компанид учруулсан хохирлыг бүрэн хариуцаж төлнө. Хохирол төлүүлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 12 хоногийн дотор төлбөрийг компанид төлнө.

7.8. Хувьцаа эзэмшигч төлбөр төлөхөөс татгалзсан буюу зайлсхийсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр түүний ногдох хувь буюу тухайн жилд олгогдвол зохих ногдол ашгийн хэмжээг төлбөрийн дүнгийн хэмжээгээр хасч болно. Ийм боломжгүй тохиолдолд төлбөрийг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

7.9. Хувьцаа эзэмшигч нь энгийн хувьцаа, ногдол хувь эзэмших эрхээ бүгдийг буюу хэсгийг гуравдагч этгээдэд худалдах буюу шилжүүлэх саналтай бол энэ тухайгаа бусад хувьцаа эзэмшигчдэд бичгээр мэдэгдэнэ. Хувьцаа эзэмшигчид хувьцааг давуу эрхийн дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эсэхээ 30 хоногийн дотор. Энэ хугацаанд хариу мэдэгдээгүй бол мэдэгдэлд дурдсан бусад шилжүүлэх, худалдахыг зөвшөөрсөн гэж үзнэ.

7.10. Хувьцаа эзэмшигч компанийн гишүүнээс гарах тухай өргөдлөө хувьцаа эзэмшигчдийн хуралд нэг сараас доошгүй хугацааны өмнө гаргана. Хувьцаа эзэмшигчийг компаниас гаргах тухай шийдвэр, дүрэмд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хувьцаа эзэмшигчийг компаниас гарсанд тооцно. Хувьцаа эзэмшигч компаниас гарахад дор дурдсан хөрөнгө олгоно:

- Хувь нийлүүлсэн хөрөнгийнх нь үнэ (өртөг)
- Уг гишүүнд ногдох ногдол ашиг

НАЙМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ХОРИГЛОХ ЗҮЙЛ.

8.1. Компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглах

8.2. Компанийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй ямарваа үйлдэл хийх

ЕС. КОМПАНИЙН УДИРДЛАГА ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ.

Компанийн удирдах дээд байгууллага

- 9.1. Компанийн удирдах буюу эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал болно.
- 9.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 9.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор хуралдуулна.
- 9.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг "Компанийн тухай" хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу хуралдуулж болно.
- 9.5. Хувьцаа эзэмшигч нь хуралд өөрийн биеэр оролцоно. Хэрэв өөрийн биеэр оролцож чадахгүй тохиолдолд "Компанийн тухай" хуулийн 68 дугаар зүйлд заасныг баримталж болно.
- 9.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэлгэрэнгүй тэмдэглэл, тогтоол зэрэг баримт бичиг үйлдэгдэнэ.
- 9.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр дараах асуудлуудыг шийдвэрлэнэ. Үүнд: - дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах - дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх - компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах - баланс, тайлан хэлэлцэж батлах - компаний эрх бүхий албан тушаалтанг /Ерөнхий захиралыг/ томилох
- 9.8. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
 - компанийн хэтийн төлөв, стратегийг тогтоож, бизнес төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
 - компанийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц, цалингийн сан, урамшууллын журмыг тогтоох
 - компанийн нийт биет эд хөрөнгийг захиран зарцуулах - компанийн гүйцэтгэх захирлыг томилж компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар Ерөнхий захирлын эрх хэмжээг гэрээгээр тогтоох
 - Ерөнхий, захирлын болон компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавих
 - дүрмээр зохицуулагдахгүй харилцааг зохицуулах журам батлаж хэрэгжүүлэх
 - компанийн баланс тайлан болон дүрмийн санд өөрчлөлт оруулах, өөрчлөлтийн талаар дүгнэлт, төслийн санал боловсруулж хуралд оруулж хэлэлцүүлэх
 - гадаад дотоодын байгууллага, компаниудтай гэрээ байгуулах, хамтран ажиллах талаар зарчмын шийдвэр гаргах, хяналт тавих - ашиг алдагдлын хуваарилах журмыг тодорхойлох, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх

- жилд нэгээс доошгүй удаа хуралд ажлыг тайлагнах
- Монгол улсын хууль, дүрэм, журамд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

9.9. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн бизнес үйл ажиллагааны үндэс болох хамт олны нэгдмэл ажиллагааг хангах үүднээс хатуу чанд сахилга бат, ёс суртахууны зөв орчинг хангах үүрэг журам батлан хэрэгжүүлэх бөгөөд зарчмын үүргээ биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтанг ажлаас халах эрх эдэлнэ.

9.10. Удирдах дээд байгууллагын бүрэн эрхийг компанийн дүрмээр зохицуулна.

Компанийн гүйцэтгэх захирал

9.11. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдан зохион байгуулна. Захиралыг хатуу тогтоосон хугацаатай гэрээний үндсэн дээр Ерөнхий захирал томилон ажиллуулна. Ерөнхий захирал хувьцаа эзэмшигчдийг төлөөлж захиралтай гэрээ байгуулна.

9.12. Захирал нь хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарахаас бусад компанийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг шийвэрлэх эрхтэй. Захиралын бүрэн эрхэд:

- Эрх бүхий харилцаанд компанийг төлөөлөх - Компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлцэл байгуулах
- Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, тэдгээрийн цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох

- Бүрэн эрхийнхээ асуудлаар тушаал гаргах

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон эрх хэмжээний хүрээнд компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах

9.13 Захирал нь компанийн үйл ажиллагааны үр дүн, гэрээний биелэлтийг жилд нэгээс доошгүй удаа Ерөнхий захирал, хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнан дүгнүүлж байна.

9.14. Захирал нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ Ерөнхий захиралд бичгээр мэдэгдсэнээр хөлсөөр ажиллах гэрээг цуцлах эрхтэй.

9.15. Захиралд хариуцлага хүлээлгэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Хариуцлага хүлээлгэх үндэслэл нь "Компанийн тухай" хуулийн 85-р зүйлийг зөрчсөн буюу тайлан тэнцлийн үр дүнгээр батлагдсан байвал зохино.

АРАВ. НОГДОЛ АШИГ, КОМПАНИЙН ӨМЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ.

10.1. Компанийн ногдол ашиг хувиарлах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана. Энэ шийдвэрт хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээгээр ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтооно. Хувьцаа эзэмшигчдийн хурал болох өдөр нь бүртгэлийн өдөр болно.

10.2. Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байна.

10.3. Ногдол ашиг төлсний дараах компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ дүрмийн 5.1-д заасан хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн хэмжээнээс их байна.

10.4. Ногдол ашгийг жилд 1 удаа санхүүгийн жилийн эцсийн тайлан тэнцлийг үндэслэн ногдол хувьтай нь хувь тэнцүүлэн хувиарлана. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

10.5. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.

10.6. Компани эргүүлж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хувиарлахгүй.

10.7. Компани нь энгийн хувьцаагаа хувьцаа эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авах буюу эргүүлж авах асуудлыг тухайн үед нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байна.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ХЯНАЛТ ШАЛГАЛТ.

11.1. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамж төлбөр төлнө.

11.3. Компани нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу тухайн жилийн санхүүгийн тайланг гаргана. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал хариуцна.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын дагуу тухайн жилийн санхүүгийн тайлан гаргаж нийтлүүлнэ.

Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна.

- a) Баланс
- b) орлогын тайлан
- c) мөнгөн гүйлгээний тайлан
- d) хуримтлагдсан ашгийн тайлан
- e) нэмэлт тайлбар тодруулга
- f) өр авлагын жагсаалт

11.4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал хариуцна.

11.5. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

11.6. Санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, ня-бо бүртгэл, тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн магадад хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч байна.

11.7. Хяналт шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараах баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална.

-Компанийн дүрэм түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд

-Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ

-Компанийн дотоод бичиг, баримт, материалууд

-Компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм, гэрээнүүд

-Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд

-Компанийн ерөнхий захирлын болон гүйцэтгэх захирлын тушаал шийдвэр, хурал зөвөлгөөний тэмдэглэл

-Санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, ня-бо бүртгэлийн баримт, бичиг, материалууд

-Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох баримт, материалууд

11.8. Компани нь улирал болон жил бүрийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааныхаа тайланг орлого зарлагын тайлан балансын хамт удирдах дээд байгууллага /хувьцаа эзэмшигчдийн хурал/-аар хэлэлцүүлж эрх бүхий бүртгэх байгууллагад өгч байна.

АРВАНХОЁР. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ.

12.1. Компанийн өөрчлөн байгуулах тухай ойлголтод компанийг хуваах бусад компанитай нийлэх, нэгдэх, тусгаарлах, өөрчлөх асуудлууд хамаарагдана.

12.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг "Компанийн тухай" хуулийн 18-24 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэн шийдвэрлэнэ.

12.3. Компани нь дараах үндэслэлээр татан буугдана.

- Төлбөрийн чадваргүй болж шүүхийн шийдвэрээр дампуурсан

- Үүсгэн байгуулагчийн шийдвэрээр цаашид үйл ажиллагаа явуулахгүй гэсэн

- Хуульд заагдсан бусад үндэслэлүүдээр

12.4. Компанийг татан буугдах шийдвэр гаргасан байгууллагаас татан буулгах комиссыг томилон ажиллуулана

12.5. Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжинэ.

12.6. Татан буулгах комисс нь "Компанийн тухай" хуулийн 26-29 дүгээр зүйлд заасны дагуу ажиллан, эцэст нь улсын бүртгэлээс компанийг хасуулж ажлаа дуусгавар болгоно

12.7. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид ямар нэг хохирол учруулсан бол уул хохиролыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

12.8. Компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

АРВАНГУРАВ. БУСАД АСУУДАЛ.

13.1. Энэхүү дүрэмд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

"СИЛИКАТ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ.